

XX зууны босгон дээр хувьсгалт үзэл санаа Ази, дорно дахины бусад улс орны нэгэн адил Монгол оронд нэвтэрч эхэлсэн байна. Хувьсгалт үзэл санаа Ази дорно дахины орнуудад нэвтрэхэд саад бэрхшээл мундахгүй байсан боловч Монгол нь тэр үед дэлхийн хувьсгалт хөдөлгөөний төв болж байсан Оросын ард түмэнтэй хөрш зэргэлдээ нутаглаж, нийгэм, эдийн засаг, соёлын талаар багагүй харилцаатай байснаар тэргүүний үзэл санаа нэвтрэхэд давуу талтай байжээ.

Оросын анхдугаар хувьсгалын тухай хэрэв Хятадад гол төлөв Японоос буюу тэнд суралцаж байсан хятад сэхээтнүүдээс дам сонсож байсан бол Монголд буриад зэрэг Байгал орчмын нутаг районоос шууд сонсож мэдэх боломжтой байв.

Энэ талаар ЗХУ-ын нам, төрийн зүтгэлтэн, Монголын ард түмний үнэнч нөхөр Борис Шумяцкий бичихдээ: «Монголын анхны хувьсгал гэж чухам юу вэ? гэвэл 1910 оноос 1912 дугаар он хүртэл тус улсын нийт байдалд холбогдолтой үүсгэж гарч байсан эсэргүүцэл тэмцээн олон газар зэрэгцээгээр оргилон энэхүү хувьсгалын анхдугаар шат бол Байгал далайн орчин тойрон ба өмнө зүгт суугаа Монголтой нэгэн үндэсний угсаа ба аж ахуйн талаар онц харилцаатай Буриад Монголын дунд гарсан 1905 оны хувьсгал тулсаны ач болох нь илтэд тодорхой гэрч баримттай болой» гэсэн байдаг.¹

1905 оны хавар, намар Чита, Эрхүү, Красноярск зэрэг хотуудад **сүрт жагсаал, ажил хаялт болж аж амьдрал**, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах эдийн засгийн шаардлагыг улс төрийн шаардлагатай хослуулж, Орос-Японы дайныг зогсоохыг шаардаж байв. Байгалийн өмнөх нутгийн ядуу тариачид, цэргүүд пролетари нарын талд орж большевикуудын санаачилгаар зөвлөлүүд байгуулагдаж байжээ.

Бага буурай орны ард түмэн эрх чөлөөний их хэрэгт хөрш зэргэлдээ орноосоо тус дэмжлэг ирэх явдал аль ч газрын ёс бөгөөд Оросын ард түмний улс төрийн амьдралтай танилцахад хөршийн холбоо нөлөө үзүүлэхийг үгүйсгэх үндэсгүй юм. Хил залган орших Хиагт хот бол ийм нэгэн үүд хаалга бүр 1905 оноос эхлэн болж Монгол-Оросын жирийн ард түмнээр барахгүй Монголын нөлөө бүхий Чин ван, Ханддорж зэрэг зарим феоdlууд хүртэл Хиагт хотоор очиж оросуудтай танилцаж байсан талаар 1907 онд түүгээр явсан орос хүмүүс бичдэг байжээ².

XX зууны эхээр Хиагтын 2000 гаруй хүн амын ихэнх нь мамын хотын хятад худалдаачид байсан боловч тэд Монгол орос хүмүүсийн танилцан нөхөрлөхөд хаалт болж чадсангүй. 1905 оны хувьсгалын өмнөхөн Сибирь болон түүний дотор Буриадын нутагт хаант засгийн цөллөгөнд байсан хувьсгалчид Сибирь нутгийн ажилчин ангийн хувьсгалт

¹ Б. Шумяцкий, Ц. Пирдишин. Монголын хувьсгалын үүссэн шалтгаан. УБ., 1924 он.

² Ш. Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа. (1850—1919). I боть. УБ, 1971, 237-р тал.

тэмцлийг зохион байгуулж байлаа. Түүний дотор Минусинск уездийн Шушенск тосгонд 1897 — 1900 онд сууж байсан дэлхийн хөдөлмөрчдийн их багш В. И. Ленинтэй танилцаж, түүний гарын үсэгтэй бичигтэй, бас хоёр богц номтой төрөлх тал нутагтаа буцаж ирсэн Гаривын Думбаа (1870—1932) хэмээх Монгол хүн ч байсан тухай мэдээ байдаг³. Ленин Тэнд цөллөгөөнд байхдаа «Оросын социал-демократуудын зорилго» гэх мэт алдарт зохиолуудаа туурвихын зэрэгцээ Сибирийн алтны уурхайн ажилчид, нутгийн тариачдын аж байдалтай танилцаж хуулийн зөвөлгөө өгч, тэдний дунд суртал нэвтрүүлгийн ажил зохиодог байснаас үзэхэд Манж-Хятадын мөрдлөгөөс зугатан гарч Сибирийн алтны уурхайд ажиллаж байсан бололтой дээрэх монгол тэмцэгчийн тухай мэдээ сэлт нь бодит баримт байж болох бүрэн үндэстэй юм.

Монгол, Оросын ард түмний уламжлалт харилцаа ганц буриадын чиглэлээр биш баруугаар Казахстан, Алтайн хязгаар, Тува, Зүүн талаар Алс дорнодын чиглэлээр нэгэн адил өрнөж байсан нь мэдээжээ.

1897 оноос эхлэн Хиагтад гарах болсон долоо хоног тутмын сонин «Байкал»-д оросын ба гадаадын мэдээнээс гадна Монгол, Хятадын талаар бичиж 1905 оны хувьсгалын үзэл санааг тусгаж байснаас гадна Хиагтын Музейд Монгол, Хятадад зориулсан тасаг нээгдэн ажиллаж байжээ. Хиагттай залгаа орших Тройцкосавск хотод 1905 оны сүүлчээр олон тооны цуглаан болж хаант засгийг түлхэн унагаахыг уриалсан тунхагуудыг тараажээ. Энэ бүхэн Монголын ард түмний сонорт хүрч байсан нь лавтай. Түүгээр барахгүй 1905-1907 оны хувьсгалд идэвхтэй оролцож явсан хувьсгалчид хаант засгийн мөрдлөг хавчилтаас зайлж 1912 оноос хойш Монголд ирж амьдарч, ажиллаж байсан бөгөөд тэдний дотор 1905 онд « Потемкин» хуягт онгоцонд гарсан бослогод оролцсон И. Н. Черепанов, 1905—1907 оны хувьсгалд цэргийн албанд байхдаа оролцож явсан М. И. Кучеренко, Украйны хувьсгалт хөдөлгөөнд оролцсон Я. В. Гембаржевский, ОСДН-ын гишүүн, буриадын цогт хувьсгалч Ц. Ц. Ранжуров,⁴ багш П. П. Данчинов нарын зэрэг хожим манай ардын хувьсгалын үйл хэрэгт хүчин зүтгэж явсан нэрт хүмүүс цөөнгүй байжээ.

Монголд Орос орноос ирж суух болсон ядуу тариачид ба дэвшилт үзэлтэн хүмүүс их Оросын ард түмний эрх чөлөө эрмэлзэх хүсэл зориг, хувьсгалт үзэл санааг Монголын тал нутгаар түгээгчид болж байсан нь цаашдаа манай хоёр орны хувь заяаг нэгтгэх хэтийн төлөвийг нээсэн дэвшилттэй үзэгдэл болов⁵.

1905—1907 оны хувьсгалаас хойш нийт дорно дахины ард түмний дунд хувьсгалт үзэл санаа дэлгэрэх явдал эрс нэмэгджээ. Энэ нь хувьсгалын нөлөө, тухайлбал ард түмэн хаант засгаар буулт хийлгэж Парламент, Үндсэн хуульт ёсыг тунхагласан нь дорно дахины улс түмэнд колоничлолын түшиг тулгуур бологч феодалын дарангуйлагч дэглэмтэй тэмцэх чухал зэвсэг болох нь ойлгогдож байжээ. Ингэж хувьсгалт үзэл санаа эрчимтэй дэлгэрэх болсон нь Иран, Турк, Хятад мэт хагас колонийн оронд хөрөнгөтний хувьсгал үүсч, Энэтхэг, Индонези мэт колонид үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөхөд чухал хүчин зүйл болж, улмаар Хятад, Энэтхэгт пролетарийн ажил хаях тэмцэл өрнөхөд хүргэжээ. Энэ үеэр Монгол оронд ч гэсэн Хятадын худалдаачдын өр зээлээс зугатаж аймаг хошуу дамжин хэсэг бөлгөөр дүрвэх, хэрмэл ард болох, өр-

³ С. Ичинноров. Ленинтэй уулзсан хүний сураг. «Үнэн» 1985.4.21.

⁴ Ц. Пунцагноров. 1905—1907 оны Оросын хувьсгал дорно дахин ба Монгол оронд нөлөөлсөн нь, «ДДСА» 1982 № 2(7). 63, 64-р тал.

⁵ БНМАУ-ын түүх. Дэд боть. УБ. 1968. 281-р талд

төө албыг тасалдуулах хэлбэрээр ажил хаялт өрнөсөн ба Ховд, Дайчин вангийн хүрээ зэрэг газар байсан Оросын эрхэлсэн ноос угаах газруудын монгол ажилчдын дунд ажил хаялт нэг бус удаа гарчээ.⁶

Орос-Японы дайны ид үед эхэлсэн Оросын 1905 оны хувьсгалын тухай өгүүлэлдээ Японы болон олон улсын ажилчны хөдөлгөөний нэрт зүтгэлтэн С. Катаяма бичихдээ: «...XIX зууны эхээр Францын гүйцэтгэсэн үүргийг XX зууны эхээр Орос гүйцэтгэж байна. Өрнөд Европ дахь хувьсгал Францаас дохио хүлээдэг байсан шиг дорно дахины тонон дээрэмдүүлж дарлагдсан орнууд одоо Оросын хувьсгалын дохиог хүлээн байна. Хятадыг харцгаа! Солонгосыг харцгаа! Бид хүлээж байна!» гэж хувьсгалыг талархаж байв.⁷

Оросын анхдугаар хувьсгалыг дэмжиж талархсан хөдөлгөөн Европ, Америкийн том хотуудад өрнөж, Орост туслах «фонд» байгуулж, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх хурал цуглаан зохиож олон улсын ажилчны хөдөлгөөний нэрт зүтгэлтнүүд (А. Бебель, К. Либкнехт, р. Люксембург, К. Цеткин зэрэг) илтгэл яриа хийж ном, өгүүлэл нийтлүүлж байв. Оросын хаант засгийг түлхэн унагаах тэмцэлд оросын ажилчин анги, түүний социал-демократ нам өөрийн стратеги, тактикийг тусгасан программтай оролцсон юм. Хаант засгийн эсрэг тэмцэлд оросын тариачид Лениний хэлснээр тариачны зөвхөн эдийн засгийн бус, бас улс төрийн анхны том хөдөлгөөн өрнүүлж ажилчин ангийн холбоотон гэдгээ харуулсан юм. Ийм ч учраас чухам 1905—1907 оны хувьсгалын үед ажилчны, дараа нь тариачны болон цэргийн зөвлөлүүд байгуулагдсан нь 1917 оны социалист хувьсгалаар тогтсон Зөвлөлт засгийн анхны үр хөврөл байв. Энэ утгаараа ч гэсэн Оросын 1905—1907 оны хувьсгал нь Октябрийн социалист их хувьсгалын ерөнхий бэлтгэл болсон байна.

1905—1907 оны Оросын хувьсгалын өөр нэг онцлог нь тэмцлийн хэлбэрийн хувьд пролетарийн хувьсгалын шинж болох ажил хаях хөдөлгөөнийг хүчтэй өрнүүлсэнд оршино.

Оросын хотуудад зөвхөн 1905 оны эхний нэг сарын дотор түүнээс өмнөх 10 жилд гарсанаас илүү олон тооны ажил хаялт гарсан байна. Ийм ажил хаялтыг өрнүүлсний хүчинд ажил хаялт бүх нийтийг хамарсан улс төрийн тэмцэл, зэвсэгт бослогын хэлбэрт шилжжээ. Улс төрийн ажил хаялт хаант засгийн түшиг тулгуур болдог арми, флотод хүртэл дэлгэрсэн байна.

Ингэж Оросын анхдугаар хувьсгалын явц дунд олж авсан туршилга Оросын ард түмэн 1917 оны 2-р сард улигт хаант засгийг түлхэн унагааж мөн оны 10-р сард хөрөнгөт ёсны ноёрхлыг устгахад нь тусалсан билээ. Оросын хувьсгалын цуурай хөрш зэргэлдээ Монгол, Хятадад нөлөөлөх Азийн бүрэг бүдүүлэг байдлыг эцэс болгохын эхлэлт болж В. И. Лениний бичсэнчлэн дэлхийн капитализм, 1905 оны оросын хөдөлгөөн хоёр Азийг бүрмөсөн сэрээв. Дундад эртний үеийн зогсонги байдалд нухлуулан зэрлэгшсэн олон дүнчүүр хүн сэрж, шинэ амьдрал, хүний хамгийн наад захын эрх чөлөө, ардчлалын төлөө тэмцэлд бослоо.

Оросын анхдугаар хувьсгал дорно дахины дарлагдсан ард түмний нүд чихийг нээж өглөө. Тэдэнд ялангуяа хаант ёс гэгч тэнгэрээс заяагдсан хөдлөшгүй зүйл огт биш, харин түүнийг эвдэн өөрчилж, өөр дэвшилтэй ёс дэглэмээр сольж болно гэдгийг харууллаа. Энэ нь Монголын ард түмний хувьд тэднээс Манж-Хятадын колончлогчдын эсрэг үндэсний эрх

⁶ БНМАУ-ын түүх. Дэд боть. УБ. 1968. 410-р тал

⁷ Революция 1905—1907 годов. Документы и материалы. М., 1975, с. 348. 8 В. И. Ленин, Зохиолууд. УБ., 1966. 19-р боть, 72 дахь тал

⁶ Ч, Жүгдэр. XIX—XX зууны зааг дахь Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. УБ., 1972. 22 дахь тал

чөлөөний тэмцэлд өрнүүлж улс орныхоо төрийн тусгаар тогтнолыг сэргээх тэмцэлд улам зоригжуулсан дуудлага боллоо.

Оросын анхдугаар хувьсгалын үе дэх Монгол

XIX зууны сүүлч XX зууны эхээр чухамдаа Хятад, Солонгос, Монгол гурав империалистуудын хоорондох зөрчлийн Алс Дорнод дахь зангилаа газар болж хувирчээ. 90-ээд оны сүүлчээр Сибирийн төмөр зам тавьж дуусгасанаас хойш хаант засгийн гадаад бодлого дахь Монгол орны стратегийн ач холбогдол нэмэгдэж эхлэв. Хаант засгийн байгуулсан Төмөр зам нь Манжуур ба Монголын хувьд явуулж байсан Хаант Оросын харгис бодлогыг хүчтэй болгоход нэмэр болохын зэрэгцээ тээвэрт Монголын ердийн хөсгийн эзлэх хувийн жинг бууруулав. Гэхдээ хилд ойролцоо төмөр зам байгуулсан явдал Монголд нааштай нөлөө үзүүлсэн нь гарцаагүй бөгөөд учир нь чухам энэ үеэс Монголын эдийн засгийн амьдралд Оросын империализмын нөлөөлөх явц эрчимжиж Монгол нь өөрийн гэсэн товартайгаар капиталист зах зээлийн давцан дээр гарч ирэв. Тухайлбал, 1900 онд Орос, Франц, Бельгийн хувь нийлүүлсэн Монголд анх удаагийн алтны томоохон уурхай «Монгол-ор» Орхоны хөндийд байгуулсан ба мөн онд Орос-Хятадын банкны салбарууд Хүрээ, Улиастайд нээгджээ. Удалгүй Хүрээ, Ховд, Улиастайд худалдааны «Орос-Монголын нөхөрлөл» болон 1905 онд Оросын консул Улиастайд, 1911 онд Ховдод тус тус байгуулагджээ. Энэ мэтээр XX зууны босгон дээр Хаант Орос болон империалист бусад гүрнүүдээс Монголд явуулах бодлого идэвхжсэнтэй холбогдож Чин улсаас Монголд «Шинэ засгийн бодлого» нэртэй шинэчлэлт явуулсан нь Манжийн баримталж ирсэн хуучин бодлогыг бүхэлд нь Хятадчилж чангалах журмаар хууль дүрмээ өөрчилж, Монголыг бүхий л талаар колончлох, умрад хөрш Орос улсаас улам бүр зааглан хөндийрүүлэхэд чиглэгдэж байв.

Энэ зорилгоор 1906 онд Бээжинд Монголруу явуулах «нүүдэл иргэдийн товчоо» байгуулж юуны өмнө Өвөр Монголд атар хагалах нэрийдлээр үй түмэн хятад иргэд шилжүүлэн суулгаад дараагийн ээлжинд нь Халхын умард хил хүртэл хятад иргэд тархаан суулгах болов. Энэ талаар Грумм-Гржимайло бичихдээ: Орос-Японы дайны дараахан Байгалын чанадах буриадууд болон, Оросын Казакуудтай нөхөрлөдөг монголчуудыг хилийн орчмоос нүүлгэн оронд нь нүүдлийн хятад иргэдийг суулгах шийдвэр Бээжинд гарсан байна гэжээ¹⁰.

Ийм шийдвэр гаргах болсон нь нөгөө талаар тэр үед Монгол, Оросын харилцаа өргөжиж байсныг ба түүнийг улам гүнзгийрэхээс Бээжингийн засгийн газар ихэд айн болгоомжилж урьдчилан сэргийлж байсныг харуулж байна.

Өөр нэг эрдэмтний бичсэнээр 1905-1907 оны хувьсгалын дараагаар Манж улс умард хилээ батлан чангалах арга хэмжээндээ Су вангийн төсөл гэгчээр Оростой хил залгасан Монголын хойд хязгаарын дагуу туушд нь 100 верст* өргөн газар хятад иргэдээр дүүргэсэн бүс байгуулах шийдвэр гарсан бөгөөд түүгээр хятадын хаалт»¹¹ буюу О. Латтиморын нэрэлснээр «амьд цагаан хэрэм» болгох ёстой байв.

¹⁰ Грумм-Гржимайло Г. Е. Западная Монголия и Урянхайский край т. III выл II. л., 1930. с. 473.

* 1 верст (мод) нь 1,0668 км-тэй тэнцэх оросын хуучин хэмжээ

¹¹ А. Н. Калинин. Народно-революционное движение до автономного периода Монголии. -«Рев. Восток» No 5 1934. с. 143.

Манжийн «шинэ засгийн бодлого»-ын нэг чухал зүйл нь энэхүү нүүдэл иргэдийн асуудал байсан ба учир нь тэд Орос Монголын харилцааг зааглан таслах, умард хилээ батлан чангалах давхар давхар үүрэгтэйн дээр хамгийн гол нь Монголын бэлчээр нутгийг эзэмшиж тариаланд зориулах, Монголыг нийтэд нь дотоод мужын нэгэн адил хятадчлахад оршиж байв.

Өгүүлэн буй үед, Монголчуудын эдийн засгийн гол үндэс болсон мал аж ахуй феодал ноёд, гадаадын шунахай худалдаачдын түүхий эд, төлбөрийн хэрэгсэл болж хувирах тийш хандсанаас малчин ардын амь зуулт өдрөөс өдөрт доройтож бүхэл бүтэн аймаг, хошуугаараа хүртэл хоосрох ядуурч байжээ. Засагт хан аймгийн нийт ард түмний байдал 1903 онд бослого гаргахад хүрсэн Дархан бээлийн хошуунаас дээргүй байв.

1889—1902 онд үргэлжилсэн Цэцэн хан аймгийн Сансрайдоржийн хошууны бослого нь Хятадын худалдаачид ба мөнгө хүүлэгчдэд тавьсан өрийг төлөх хөрөнгөгүй болсонтой холбогдон гарчээ.¹² Цэцэн хан аймгийн бусад хошуудын эдийн засгийн байдал ч Сансрайдоржийн хошууныхаас өөрцгүй байв.

1911 онд Хятадын пүүсүүд Монголын хөдлөх хөрөнгөний бараг ихэнхийг эзэмших болсон тул Монголын малчин ардууд хөрөнгө малынхаа эзэн байхаа больж харин өөрийнхөө нутагт хятад худалдаачдын хөлсгүй малчин болж хувирч байсан тухай гадаадын жуулчид, эрдэмтэд тэмдэглэсэн байдаг.

Зээлээр худалдаа хийх, өрийг өрөөр улируулж үнийг малаар төлөх, хувийн өрийг хошуу даах гэх мэт дүрэмтэй, Хятадын мөнгө хүүлгэх капитал, дотоодын феодалын гурван төрлийн рент бүхий алба гувчуур энэ бүхэн нь айл аймаг, ард түмний үгүйрэл хоосролын гол шалтгаан болж өрх бүр 100—1000 хүртэл лан мөнгөний өртэй болжээ. Гэтэл Хятадын нэг худалдаачин 19-р зууны дунд үед Монголд байсан Францын жуулчин Гюке-д ярихдаа «А яа татарын өр гэгч нь юутай тааламжтай сайхан юм бэ? Естой алтан хайрцаг хэмээгч нь энэ болно» гэжээ.¹³ Ард түмний амьдрал, аж ахуйн сүйрэл улс орон даяар түгээмэл шинжтэй болж ийм байдал нь империалист гүрнүүд Монголын зах зээлийг хуваан авч тонон дээрэмдэх бодлого явуулахын зэрэгцээ тэдэнтэй өрсөлдөх замаар Манж Чин улс «шинэ засгийн бодлого» гэгчийг шамдан явуулах болсонтой уялдан XIX зууны сүүлч XX зууны эхээр улам хүндрэх болов.

Монголын нийт хүн амын дөнгөж 7,8 нь болж байсан феодалууд ашигтай билчээр нутгийн ихэнхийг бүх малын 49,5-ын хамт өмчилж байсан учраас зарим нь туйлын баяжиж феодалын томоохон аж ахуй олширч байв. Жишээ нь: 1890 онд Цэцэн хан аймгийн ван Доржпаламын хувийн мал нь 135.000 гаруйд хүрч уг аймгийн бүх малын гурваны нэг хувийг эзлэх болжээ.¹⁴ Гэвч энэ нь нийт феодалуудад хамаарах зүйл биш нь мэдээж бөгөөд зарим хошуу захирсан феодал ноёд хүртэл ялангуяа Манжийн шинэ засгийн бодлого»-ын жилүүдэд сүрхий хэлмэгджээ. Үүнийг дээр дурдсан Цэцэн хан аймгийн бэйс Сансрайдоржийн хошуу хүртэл бүхэл хошуугаараа хоосорч, засагт хан аймгийн Үйзэн гүнгийн ху-

¹² Ш. Нацагдорж. Ар Монголд гарсан ардын ардын хөдөлгөөн. УБ. 1956, 48 49-р тал, Ш. Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа 1956—1919. боть I, УБ., 1971. 223-р тал.

* Бүтээгдэхүүн, ажиллах, мөнгөн ийм гурван төрлийн рентээс гувчуур бүр тэж байсныг манай эрдэмтэд нотолжээ. (-Э. П).

¹³ Монгол нь Манж, Автономитын үед. УБ. 1939. 13-р тал.

¹⁴ Л. Гомбо. Манжийн үеийн алба гувчуур (1850-1910). УБ., 1960. 7-р тал.

вийн бүх хөрөнгө нь тэмээ 2, адуу 12, үхэр 9, болсон¹⁵ зэрэг баримт гэрчлэнэ.

20 гаруй төрлийн 50 гаруй нэр бүхий албан гувчуур нь нийт ард түмний нуруунд маш хүндээр тусч байснаас 1855 онд түшээт хан аймагт амь зуух аргагүй гар хоосон хүн 32.000 гаруйд хүрч 5000 гаруй хүн өлсгөлөнд нэрвэгдэж байсан бол 1882 онд мөн аймгийн ганцхан Говь-мэргэн ван (одоогийн Дорноговь аймгийн нутаг)-ийн хошуунд огт гар хоосон хүн 9000 шахамд хүрч 1200 гаруй хүн өлсгөлөнгөөр үхэж байжээ.¹⁶ Энэ бол хүн амаар маш цөөхөн тэр үеийн Монгол орны хувьд харьцуулж үзвэл үнэхээрийн сүйрэлт болж үхэх мөхөхийн даваан дээр гарсны тэмдэг харагджээ.

Манжийг эсэргүүцсэн хөдөлгөөн Хятадын худалдаачдад тавьсан засаг ноёдын өрийг хүчингүй болгох, цэргийн алба, өртөө улааг тасалдуулах, нутаг бэлчээрээ тариалангийн талбай болгохыг эсэргүүцэх зэрэг янз бүрийн хэлбэрээр гарч тэр нь бүр 1905—1907 оны үед Халхын бүх аймгийг хамарч байжээ. Үүнийг мөн үед Түшээт хан, Цэцэн хан, Сайн ноён хан зэрэг нутаг оронд гарч байсан хэрэгтэй холбогдуулан хошуу ноёдоос Манжийн засгийн газарт мэдүүлж байсан өргөдөл, мэдүүлэг, түүнд ирж байсан хариу зэрэг олон тооны баримт бичиг гэрчилж байна.

1905—1907 онд халхын Цэцэн хан, Түшээт хан аймаг, их шавь, Хүрээнд гарч байсан хэргүүдээс зөвхөн 12 зүйлийн зарга мэдүүлгийг авч үзэхэд:

— Хятадын худалдаачдын мөлжлөг, тэдэнд тавьсан засаг ноёны өрийг төлөхийг эсэргүүцсэн-2

— Олон хошууд үгүйрч ядуурсан учраас олон төрлийн алба залгуулан чадахгүй болсон хийгээд тэгш бус ноогдол албыг эсэргүүцсэн-4

— Манжийн хуурай замын агт гаргах, тусгай сайдын өртөөг зал гуулах албыг эсэргүүцсэн—2

— аймаг, хошуудад амь, албаны тариа тарихыг эсэргүүцсэн-2

— Алтны уурхай нээхийг эсэргүүцсэн-1

—Хурал номын хэрэглэл нийлүүлэх алба хүндэрч, өр ихэдсэн явдлыг илэрхийлсэн-1 байна.¹⁷

Харийн худалдаачид, феодал ноёд, сүм хийдийн алба татварт хөрөнгө малаа барьж дуусгаад зарц ядуус болох, улмаар аймаг хошуугаараа өр төлбөрт унаж ядуурч доройтох үзэгдэл түгээмэл болсныг дээрх цөөн баримтаас ч олж харж болох юм.

Гадаад, дотоодын дарлал мөлжлөг ийнхүү хурцадсан учир ангийн тэмцэл ширүүсч империализм ба феодалыг эсэргүүцсэн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн Монголын ард түмний нийгмийн бүх давхаргыг хамтрах болов.

Монгол дахь хувьсгалт хөдөлгөөний нэг томоохон төв нь Ховдын хязгаар байлаа. 1903 онд Засагт хан аймгийн Дархан бээлийн хошууны ард Аюушаар удирдуулсан «Цэцэг нуурын дугуйлангийнхан» Хятадын шунахай худалдаачид ба дотоодын феодал ноёдын эсрэг боссон ардын хөдөлгөөн 1906 онд Засагт хан аймгийн бараг бүх хошуудыг хамарсан байна. 1906 оны 10-р сард Манж Хятадын захиргаанаас хятад монгол

¹⁵ Грумм-Гржимайло. «Монголын түүх» 6-р дэвтэр. УБ., гар бичмэл УННС.

¹⁶ Л. Гомбо, Дурдсан зохиол. 9-р тал.

¹⁷ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл (баримт бичгийн эмхтгэл 1900—1914) УБ., 1982. 16--62-р талд.

нийлсэн зэвсэг бүхий 100 морин цэргийг тусгайлан гаргаж явуулснаар сая Цэцэг нуурын дугуйланг зэвсгийн хүчээр дарсан байна.¹⁸

1910 оны эцсээр Их хүрээнд Манжийн захиргааг эсэргүүцсэн лам нар ба харчуудын бослогын чанартай томоохон үймээн гарч 12-р сарын 27-нд Да Ию пүүсийг дайрч «Манж-Хятадын мөлжигчид Монгол орноос зайлсугай» гэдэг уриан дор тэмцэж пүүсийн дэлгүүр хоршоог эвдэж 700 гаруй лан мөнгө, 160 гаруй янчааныг булаан авчээ. Үймээнд 2-3 мянган лам нар¹⁹ оролцсон мэдээ байдаг нь тэдний дотор хотын энгийн ард иргэд хавсран нийлснийг хамтруулсан тоо бололтой. Үймээнд лам нар төдийгүй хотын иргэд оролцож, Хятадын худалдаачдыг зайлахыг шаардсан ба Сандо амбаны биед халдсан хийгээд босогчдыг хүрээний цагдан сэргийлэх галт зэвсгийн хүчээр намтгасан зэргээс үзэхэд тэр нь ганц Да Ию пүүсийн эсрэг биш Манжийн захиргааны эсрэг чиглэсэн бослого байв. Сонирхолтойгоос лам нар бослогын үед Гандангийн зүүн хажууд бөөгнөрч «шулмасыг хөөн тонилгох ном», «хар Хятадын тотгорыг арилгах ном» гэгч хараал зүхлийн ном уншиж байжээ.²⁰

(Үргэлжлэл бий)

¹⁸ Ш. Нацагдорж, Халх дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ба феодалыг эсэргүүцсэн хөдөлгөөнүүд. УБ. 1941, 18-р тал.

¹⁹ Яно. Монголын орчин үеийн түүхийг нягтлах бичиг. УННС. гар бичмэл, Гуравдугаар боть.

²⁰ Л. Лувсанчүлтэм. Оросын 1905 оны хувьсгал Монголд нөлөөлсөн нь. «Дорно дахины судлалын асуудал» No 1(4), УБ, т. 49. 1981.